



199  
119

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 91

Есөнбулаг сум

**Нийтийн сонсгол зохион  
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Монгол улсын нийтийн сонсголын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Монгол Улсын Их хурлын 2017 оны 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 2016 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн санхүүжилт, зарцуулалтын талаар төсвийн хяналтын нийтийн сонсголыг 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Алтай хотод зохион байгуулахаар тогтсугай.
2. Нийтийн сонсголыг даргалах болон оролцох хүмүүсийг хавсралтаар баталсугай.
3. Нийтийн сонсголыг хууль, журмын дагуу чанартай зохион байгуулахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Мөнхтөр/-д даалгасугай.

ДАРГА

Т.ГАНЗОРИГ



0200396

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2017 оны 10-р сарын 24-ний өдрийн  
200  
120  
24-р тогтоолын хавсралт

НИЙТИЙН СОНСГОЛД ОРОЛЦОХ ИРГЭД,  
БАЙГУУЛЛАГА, АЖИЛТАН, АЛБАН ХААГЧИД

Сонсгол даргалагч: Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч Д.Амартүвшин

1. Аймгийн ИТХ-ын ажлын алба
2. Аймгийн ИТХ-ын санхүү эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогын хорооны Төлөөлөгчид
3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс
4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
6. Аймгийн Орон нутгийн Өмчийн газар
7. Аймгийн Төрийн аудитын газар
8. Есөнбулаг сумын ИТХ-ын ажлын алба, ИТХ-ын Тэргүүлэгчид
9. Есөнбулаг сумын Засаг дарга
10. Есөнбулаг сумын ЗДТГ-ын дарга
11. Есөнбулаг сумын төрийн сангийн мэргэжилтнүүд
12. Есөнбулаг сумын 10 багийн Засаг дарга
13. Есөнбулаг сумын 10 багийн ИНХ-ын дарга
14. Есөнбулаг сумын 10 багийн Нийгмийн ажилтнууд
15. Есөнбулаг сумын баг тус бүрээс 10-15 иргэд
16. Аймгийн ТББ-уудын Нэгдсэн Зөвлөлийн тэргүүн Г.Ундрам

-----oOo-----